

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/113/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: **Ч.Цэрэннадмид**

Утас: **9511-2689, 89275858**

Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-уул аймаг
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙХИШИГ ТАНАА

2022.02.25 № 204
талай -ны №

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР/



009070309

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	7.6	22.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	15.6	18.8
	Нийт хөрөнгийн дүн	23.2	41.2
	Нийт өр төлбөрийн дүн	0.0	0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	23.2	41.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	52.8	83.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	63.7	65.9
	Үйл ажиллагааны үр дүн	(10.9)	18.0
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(10.9)	18.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23.2	41.2
	Тайлант оны үр дүн	(10.8)	18.0
	Эцсийн үлдэгдэл	23.2	41.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	51.7	76.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	51.7	70.2
	Үйл ажиллагааны ЦМГ	0.0	6.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0.0	6.3
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	51.7	51.7
	Урсгал зардал	51.7	51.7
	Хөрөнгийн зардал		6.3
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	50.8	51.7
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн сум дундын ойн анги нь Дархан-Уул аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу 2017 оны 1 сард байгуулагдсан. Сум дундын ойн анги нь 3 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Сум дундын ойн анги нь ойг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах талаар нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх “Ойн менежментийн төлөвлөгөө”-тэй болж төлөвлөгөөний дагуу ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг явуулж хамтран ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд Дархан, Орхон, Шарын гол, Хонгор сумдын нийт 81997 га талбайг хариуцан хамгаалах, ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх, зүй зохистой ашиглах чиглэлээр нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлж ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд 4 сумдын 74 ойн нөхөрлөл, 7 ойн мэргэжлийн байгууллагуудад мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч хамтран ажиллаж байгаа бөгөөд сум дундын ойн ангийг түшиглэн олон улсын хэмжээний 2 төрлийн төсөл хэрэгжиж байна.

Бүгд найрамдах Чех улсын Засгийн газар, Монгол улсын Засгийн газрын хамтын ажиллагааны хүрээнд Дархан-Уул аймгийн Хонгор суманд хэрэгжиж буй “Монгол орны ойн болон орон нутгийн ой модны генийн сангийн хөгжил төсөл”-ийн багтай сум дундын ойн анги хамтран ажиллаж байгаа бөгөөд төслийн хүрээнд 6 ш хүлэмж барин хүлэмжинд шинээр нэвтрүүлж буй патрик технологиор 100.000 ширхэг бортоготой тарьцыг тарьж ургуулах, сургалт мэдээллийн төв байгуулан хээрийн болон танхимын сургалт явуулж байна.

Сум дундын ойн анги нь төслийн хүрээнд бий болсон сургалтын баазын үйл ажиллагааг тогтвортой явуулах зорилгоор 2018 онд БНЧУлсын Элчин сайдын яамнаас зарласан жижиг төсөлд шалгарч үржүүлгийн төвийн цахилгааны эх үүсвэрийг бүрэн шийдэх нарны зайн эх үүсвэрийг худалдан авах зорилгоор 47 сая төгрөгийн гэрээг БНЧУлсын элчин сайдтай байгуулж ажилласан.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 2 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

[illegible]

